

“ГУТАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022.04.29

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН нь:

“Гутал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2022.04.29-ны өдрийн 10¹⁰ минутанд “Гутал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн өрөөнд эхлэв.

Тус хуралд:

1. Ц.Төмөр- биечлэн
2. Т.Билэг- итгэмжлэлээр
3. Б.Батбилэг- биечлэн
4. Б.Баттөр - биечлэн
5. Б.Батхишиг- биечлэн
6. Ж.Энхрийлэн /хууль ёсны төлөөлөгч А.Жавхлан/- биечлэн тус тус оролцсон.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Э.Бат-Эрдэнэ, ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Б.Жаргал нар хуралд оролцохоор ирсэн.

Хурлын ирц:

Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 1,498,344 ширхэг хувьцаа эзэмшдэг 6 хувьцаа эзэмшигч оролцсон ба нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 95.13хувь болж байгаа.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг батлах;
4. 2021 оны ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний үндэслэлийг танилцуулах.
5. Компанийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг танилцуулах;

Хурал даргалагч: ТУЗ-ийн дарга Б.Батбилэг

СОНССОН нь:

Батбилэг: Сайн байцгаана уу. Өнөөдрийн хурал эхэлснийг мэдэгдье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүрдсэн тул хэлэлцэх асуудлуудаа хэлэлцээд явъя.

Гутал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг та бүхэнд цаасаар болон файл хэлбэрээр тараасан. Үүнтэй та бүхэн сайн танилцсан байхаа. Эхний хэлэлцэх асуудал Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах байгаа.

ТУЗ-ийн зүгээс дүгнэлтээ 2021 оны 03-р сарын 16-ны өдөр гаргасан. Үүн дээр хэлэх санал байна уу.

Төмөр: Санал байхгүй.

Хуралд оролцсон бүх хувьцаа эзэмшигчид 100 хувийн саналаар батлав.

Батбилэг: Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлаа ярилцъя. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооноос 2022 оны 03-р сарын 14-ний өдөр хуралдаж, нийт 10 хүний нэрийн дэвшүүлж байгаа. Нэр дэвшигч нарын танилцуулгатай та бүхэн танилцсан байхаа. Та бүхэн саналын хуудсаараа сонгох хүмүүсдээ саналаа өгнө үү.

ТУЗ-ийн гишүүнээр Ц.Төмөр, Б.Батбилэг, Т.Билэгт, Б.Баттөр, Б.Батхишиг, Ч.Цэцэгмаа, хараат бус гишүүнээр Э.Билгүүн, Б.Жаргал, С.Бат-Эрдэнэ нар сонгогдлоо. Баяр хүргэе.

Одоо компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг батлах асуудал байна. Жил бүрийн ТУЗ-ийн төсөв хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлагддаг. Энэ жилийн тухайд нийт 141 900 000 төгрөг байна. Энэ жилээс ТУЗ-ийн гишүүний урамшуулал 1,000,000 төгрөг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин 600,000 болж нэмэгдэх саналыг ТУЗ-өөс зөвшөөрсөн байгаа. Та бүхэн саналаа өгөх үү.

Төмөр: Санал байхгүй. Дэмжиж байна.

Баттөр: Дэмжиж байна.

Батхишиг: Татгалзах зүйл байхгүй. Дэмжиж байна.

Батбилэг: Дэмжиж байна. ТУЗ-ийн төсөв ийнхүү батлагдлаа. Дараагийн хэлэлцэх асуудал бол 2021 оны ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний үндэслэлийг танилцуулах байна. Еид ТУЗ-ийн 2022 оны 02-р сарын 16-ны өдөр ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан. 2021 оны үйл ажиллагааны ашгаас нэгж хувьцаанд 1,427 төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэрлэсэн болно.

Хамгийн сүүлийн хэлэлцэх асуудал бол Компанийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг танилцуулах юм. Аудитын компаниар “Нийслэл аудит” ХХК ажилласан ба аудитын дүгнэлттэй та бүхэн танилцсан байхаа.

Та бүхэн одоо санал хураах хуудсаа үнэн зөв, алдаагүй бөглөж өгнө үү. Тооллогын комисс тооцоог нь гаргаж танилцуулах болно.

Өнөөдрийн гаргасан шийдвэрүүдийг танилцуулав. Өнөөдрийн хурал дууслаа. Баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Дараах шийдвэрийг өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар гаргав. Үүнд:

1. Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн

саналаар батлав.

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгов.

1. Б.Батбилэг
2. Б.Баттөр
3. Б.Батхишиг
4. Ц.Төмөр
5. Т.Билэгт
6. Ч.Цэцэгмаа

3. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгов.

1. Э.Билгүүн
2. Б.Жаргал
3. С.Бат-Эрдэнэ

4. "Гутал" ХК-ийн 2022 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг 1 дүгээр хавсралтын дагуу 100 хувийн саналтай батлав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 11²⁰ цагт дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

НАРИЙН БИЧИГ А.ГУЛИМ

ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА Б.БАТБИЛЭГ

